

ГАДААД МОНГОЛЫГ ХАРИУЦСАН АНУ-ЫН АНХНЫ СУУРИН КОНСУЛ САМУЭЛ СОКОБИН

Доктор, профессор Д.Уламбаяр¹

Keywords: Outer Mongolia, consul, resident, open the door, attache, minister, His Holiness the Government, company, Department of State, Department of Commerce, trade, recognition, ad hoc, People's Government, note, report, Uрга, Kalgan, prime minister, foreign minister, etc.,

Abstracts: This article talks about the USA foreign policy towards Far East, especially, Outer Mongolia, first commercial linkages, how the establishment the USA first resident consulate on Outer Mongolia in Kalgan, first consul Camuel Sokobin, his first mission to Uрга and report sent to Department of State, Washington D.C, first negotiation between S.Sokobin and People's Government, S.Sokobin's diplomatic activities and his destiny.

АНУ-ын Алс Дорнодын бодлого ба Гадаад Монгол

XIX зууны сүүлчийн улиралд АНУ Хятадтай харилцах “нээлттэй хаалга”-ны бодлогыг тунхагласны дараа Гадаад Монгол нь сайхь гүрний гадаад худалдаа-эдийн засгийн ашиг сонирхлын хүрээнд нэгэнт багтах болсон байна. Нийслэл Хүрээний зүүн дэнжийг Монголчууд «Американ дэнж» хэмээн нэрлэх болсон нь Орос-Америкийн Чарльз

¹ Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

Э. Стукены «Стукен и К^о»² болон «Mongolian Trading Company», «Andersen, Meyer & Co.»-ийн салбар энд байрлаж байснаас гүн улбаатай юм. Эдгээр компаниуд Америкийн томоохон монопольт трест, синдикатуудтай холбоотой байв.

«Mongolian Trading Co» компани нь «Standard Oil Co.» компанитай, «Andersen, Meyer & Co.» компани нь Америкийн «General Electric» корпораци, «International Corporation» хэмээх санхүүгийн томоохон нийгэмлэгтэй хэлхээ холбоотой байжээ. Эдгээр пүүсүүд Шаньхай хотод төвтэй байсан байх бөгөөд салбарууд нь Тяньжин, Бээжин, Хаалган, Кантон, Харбин, Хонконг, Хүрээ зэрэг хотуудад үйл ажиллагаа явуулж байв.

1915 оноос Хаалган, Долоннуур нээлттэй хот болсноор Америкийн капитал Монголд шаргуу нэвтрэх болж, үүнийг нь Богд гэгээний Засгийн газар ч дэмжиж байжээ. 1916 оноос Америкийн худалдааны хүрээнийхэн Чуулалт Хаалганд «The Mongolian Trading Co.» нэртэй компани байгуулж, Хүрээ-Хаалганы хооронд өргөн хүрээтэй тээвэр хийх болжээ. Компанийн захирал Чарльз Л.Колтман (Charles Lilly Coltman 1891-1922) бол эцгийнхээ хамт Хятадад ирж бизнес эрхлэх болсон бөгөөд түүний эцэг Роберт Колтман (Robert Coltman 1862-1931) нь Филадельфид Жефферсоны Анагаах ухааны коллеж дүүргэж, 1886 оноос Бээжин дэх Тунь Вень коллежийн анатомийн профессор, 1898 оноос Бээжингийн эзэн хааны их сургуульд мэс заслийн профессор, сүүлд «Standard Oil Co» –ийн Тяньжин дахь зөвлөх, Бээжин дэх төлөөлөгчөөр давхар ажиллаж байжээ. Чарльз Колтман Рой Эндрюсийн сайн найз байв.

Хүрээ-Хаалганы хооронд банкны гүйлгээ байхгүй байсан учир их хэмжээний цэвэр цалин мөнгөн зоосуудыг (silver coins) Хаалганаас

2 *Stucken, Charles (Karl) Edward* (1852-1934) Чарльз Эдуардович Стукен Нью Йоркт сурвалжит гэр бүлд төрсөн. Нью Йорк хотын их сургууль бизнесийн чиглэлээр дүүргээд 1874 оноос Санкт-Петербургт, дараа нь Москвад шилжин амьдарч худалдаа эрхэлж эхэлжээ. 1882 онд орос эмэгтэй Мария Катерине-Елизавететэй гэр бүл болж, гэхдээ АНУ-ын иргэний харьяалал нь хэвээр үлджээ. 1882 онд Оросын худалдааны нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн *Gilde* болж, Москвагийн Варварка өргөн чөлөөний Китай-городод “Karl Stucken” бөс барааны фирм байгуулж, худалдааны үйл ажиллагаа эрхлэх болжээ. Москвагийн Тооцооны банкны Зөвлөлийн гишүүн, Москвагийн худалдааны шүүхийн гишүүн, Волжскийн утас зэрэг үйлдвэрийн Зөвлөлийн гишүүн, Ростов дахь “Өмнөд Бавари” шар айрагийн үйлдвэрийг эзэмшигч, 1900-03 онд Москвагийн Биржийн нийгэмлэгийн орлогч, 1903-15 онд жинхэнэ гишүүнээр ажиллаж байв. 1907 онд Оросын эзэн хаанаас үе дамжсан сурвалжит иргэншлийн жуух гардаж авчээ. 1897 оны 1 дүгээр сард бүрэн хариуцлагатай “Стукен и Ко.” компани байгуулж, Удирдах Зөвлөлд Чарльз, Данил Васильевич Стукен, Мария Львовна Стукен, Энгельберт Стукен зэрэг гэр бүл, үр хүүхдүүд нь орсон байна. 1907 онд Хүрээнд бөс бараа, цай худалдаалах салбар дэлгүүрээ нээж, монголчуудын дунд ихэд нэр хүндтэй байсныг Москва, Томскийн худалдааны ангийхан тэмдэглэж байв. Чарльз Стукен 1934 онд Берлинд нас баржээ.

Хүрээнд машинаар зөөвөрлөх шаардлага байнга гардаг байжээ. Зөвхөн 1923 онд Хаалган дахь Консулын газрын гэрчилгээтэйгээр америкийн фирмүүд 790 мянган ам. долларын өртөг бүхий мөнгөн зоос Хүрээнд шилжүүлсэн байна. Урьд нь Колтман 10 мянган ам. долларын мөнгийг Хаалганаас Хүрээнд зөөвөрлөж байжээ. Гэвч Хятадын захиргаа 1922 оны 2 дугаар хагаст цэвэр мөнгөний урсгал дээр хориг тавьсан учир Америкийн худалдаачид Хятадын Засгийн газартай хэлэлцээ хийж байжээ. Энэ үеэр Колтман консул Сокобинтой тохиролцсноор 35 мянган ам. доллартай тэнцэх цэвэр мөнгийг дипломатын дархан эрх ашиглан Хятадын гаальд шалгуулахгүйгээр явах үед гаалийнхан гал нээж, Колтман суманд оногдон шарх авч, харин сум Сокобины хажуугаар өнгөрчээ. Колтман Бээжинд эмнэлэгт ирээд 12 дугаар сарын 15-нд нас барсан байна. Энэ хэрэг Хятадад томоохон шуугиан болж, Бээжин дэх элчин сайд Я.Шурман Хятадын Засгийн газарт Америкийн консулын аюулгүй байдлыг хангаж чадахгүй байгаа, худалдаанд саад учруулж буй талаар эсэргүүцлийн ноот бичиг илгээсэн байна. Төрийн департамент Бээжин дэх ЭСЯ-нд мэдэгдэхдээ хэрэв Хятадын Засгийн газар уучлал гуйж, Боксерын протоколд заасанчлан хохиролыг даруй нөхөн барагдуулахгүй тохиолдолд АНУ-ын Конгрессоос дараагийн шийдвэртэй алхам хийх болно гэсэн байв. Колтманы хэрэг Хүрээ-Хаалганы худалдаанд маш том хохирол учруулсан тухай Алиша Кэмпн өөрийн бүтээлдээ бичсэн байна.

Үүний дараахан дани-германийн жүүд Вильгелм Мейер (Vilhelm Meyer 1860-1935) 10 мянган тээл, И.Андерсен (Ivan H.Andersen) 20 мянган тээл нийт 30 мянган тээлын хөрөнгөөр өөр нэг дани эр Адолф Петерсентэй хамтран 1905 оны 3 дугаар сард Шаньхайд бүртгүүлсэн “Andersen, Meyer & Co.,” пүүс өөрийн салбараа Хүрээнд нээхээр шийдвэрлэж, төлөөлөгчөөр нь Шведийн христ номлогч Монголыг Өрнөдтэй холбоход зүтгэл гаргасан хэмээн үнэлэгдэж, Богд гэгээнээс 1919 оны 12 дугаар сарын 30-нд “гүн” цол хүртээж, төрийн дээд “Эрдэний очир” одонгоор шагнагдсан Франс А.Ларсон ажиллах болжээ. Түүний монгол нэр нь «Ла гүн» юм. Энэ компани 1916 онд АНУ-ын бүртгэлтэй болсон байна. “A, M & Co.,” пүүс 1920 онд Нью Йоркт салбараа нээж, 1934 онд “General Electric”-тэй нэгдэж, АНУ-ын найман том гигантын нэг болсон бөгөөд Вильгелм Мейерийг “China’s

Great Dane” хэмээн нэрлэх болсон ажээ.

“A, M & Co.,” пүүсийн тухай 1994-95 онд Шаньхайд Даний Ерөнхий консул, 1995-2001 онд Бээжинд элчин сайдаар ажилласан, Мейерийн гурав дахь үеийн ач Христофер Бо Брамсен (Christopher Bo Bramsen) 2001 онд хэвлүүлсэн «Open Doors: Vilhelm Meyer and the Establishment of General Electric in China» номондоо Мейерийн удам, “Andersen, Meyer & Co.,” пүүсийн түүхийн талаар тодорхой бичсэн байна.

1919 он хүртэл дээр дурдсан хоёр компани 3 сая долларын ноос, сая ширхэг тарваганы арьс АНУ-д экспортолсон байна. Монголтой хийх дээрх хоёр пүүсийн худалдаа 1915-1920 оны хооронд түргэн өссөний ачаар Монголтой хийж байгаа худалдаагаа Америкийн Засгийн газар системтэй судлах боломжтой болжээ. АНУ-ын Худалдааны яам Америк, Хятадын худалдаанд Монголын тухай статистик мэдээг 1918 оноос тусад нь гаргах болов.

Тяньжинд суугаа АНУ-ын Консулын газар Америкийн худалдаанд Монголын ач холбогдол нэмэгдсээр байгааг тэмдэглэсэн “Монголд Америкийн худалдаа өргөжиж байгаа тухай” 514 тоот илтгэх хуудас 1920 оны 11 дүгээр сард гаргажээ. Үүнд: «Англи, Германы экспортлогчид дайралдсан түүхий эдийг Хаалганаар дамжуулан Тяньжинд авчирч, Европ, Америкийн импортлогч нарт худалдаж ирснээс биш, Монголтой худалдааг тухайлан хөгжүүлэх, Монголд гадаадын бүтээгдэхүүн борлуулах зах зээл буй болгох талаар тусгайлан арга хэмжээ авах талаар хангалтгүй байсныг тэмдэглэх хэрэгтэй. Америкийн нэг л пүүс зөвхөн 1919 онд 3 сая долларын хонины арьс Монголоос гаргаж байжээ. Монгол, Америкийн шууд, шууд бус худалдаа 1 сая орчим тээл (хятадын мөнгөний жин 1 тээл буюу лан=37.42 грамм=1.333 унц алт буюу 9.286 мөнгөн зоос Д.У), Хүрээ, Улиастай дахь шууд хөрөнгө оруулалт, газар, барилга, агуулах зэргийг тооцон хагас сая тээл болж байна. Монголд цахилгаан машин, автомашин, керосин, шатахуун, лаазалсан хүнс, чихэр, тамхи, сэлбэг зэрэг Америкийн үлэмжхэн бараа таваарыг экспортлож байна. Иймд Америкийн иргэд, хөрөнгийг хамгаалах арга хэмжээг үзэгдэхүйц хэмжээнд авахгүй бол ямар нэгэн гэнэтийн явдал тохиолдвол худалдаа буурах, тасалдахад хүргэж, энэ нь Япон, Британийн худалдаанд л ашигтай болно» гэж дээрх илтгэлд анхааруулжээ. Монгол хүний амьдрал туйлын энгийн,

хэрэглээ цөөхөн, монголчууд тамхи, гаанс, гэр ахуйн металл хэрэглэл, хөвөн, торгон бараа, чихэр худалдан авдаг. Хүрээнд хийх авто тээвэр ирээдүйтэй арилжаа болно. Америкийн автомашиныг Монголд амжилттай нэвтрүүлсэн зэргийг энэхүү илтгэлд дурьдаад Монголын худалдааны ач холбогдлыг өндрөөр үнэлж байсан тухай америкийн эх сурвалжийг үндэслэн судлаач Р.Болд өөрийн бүтээлдээ бичжээ. (1)

1919 онд Бээжин дэх АНУ-ын Худалдааны яамны атгаше Ж.Арнольд³ Хятадын худалдаан дахь Хүрээ-Хаалганы чиглэлийн ач холбогдол тууштай өсч байгааг Худалдааны департаментэдээ анхааруулж байв. Тэрбээр 1917 оноос Хүрээнд Консулын газар яаралтай нээх саналыг Төрийн департамент, Худалдааны департаментэд нэг биш удаа тавьж байжээ. Гэхдээ Сюй Шюү-чжень болон Барон Унгерны үед Өрнөдийн пүүсүүд нэлээд хохирол амссан байна.

Тухайн үед америкийн худалдаачдаас гадна судалгаа-шинжилгээний анги Монгол орныг онцгойлон сонирхож эхэлсэн явдал байв. АНУ-ын Байгалийн түүхийн музейн Төв Азийг судлах шинжилгээний ангийн удирдагч, профессор Рой Ч.Эндрюс (Roy Chapman Andrews 1884-1970) тэргүүтэй судлаачид 1919 оны намар Монголын нийслэл Өргөөд анх удаа хүрэлцэн иржээ. Тэдэнд Хүрээ-Хаалганы хооронд авто хөсгийн үйлчилгээ эрхэлж эхлээд байсан “Mongolian Trading Co”, түүний эрхэлсэн түшмэл Ч.Колтман туслалцаа үзүүлсэн байна. Зочдын хамт Бээжин дэх АНУ-ын цэргийн атгаше, хошууч А.М.Гуптил (major A.M.Guptil), ЭСЯ-ны нарийн бичгийн даргын туслах, хятад хэлний мэргэжилтэн Ернест Б.Прайс (Ernest B.Price) нар иржээ. Тэд Эрхүү дэх АНУ-ын консултай холбоо тогтоохоор явж байсан тухай, Өргөө дэх Оросын консул А.Орлов Америкийн судалгааны багийн Өргөө дэх ажлын төлөвлөгөөний талаар Монголын Засгийн газраас мэдээлэл шаардаж байсныг Эндрюс өөрийн бүтээлдээ бичсэн нь буй. Харин Алиша Кэмпи Гуптилыг Америк ажилтан биш, “Mongolian Trading Co” пүүсийн ажилтан герман хүн, мөн энэ үед Эрхүүд АНУ-ын Консулын газар байгаагүй гэж бичсэн байна.

³ Arnold, Julian Herbert (1876-1946) нь 1900 онд Берkeley дэх Калифорний их сургуулийн гадаад худалдааны салбар дүүргэж, гадаад албаны сургалтад хамрагдаж, 1902-04 онд Бээжинд хэлний мэргэжил дээшлүүлж, АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газрын туслах, 1904-16 онд Хятадын Далянь, Фүцзоу, Сиань, Яньтай, Ухань, Японы эзэмшил Формуз аралд дэд консул, консул; 1917-40 онд Бээжин дэх АНУ-ын Худалдааны департаментын Худалдааны Төлөөлөгчийн газрын атгашегаар (тэргүүн) нийт 40 шахам жил тасралтгүй ажиллажээ. «China: A Commercial & Industrial Handbook-1924» номын зохиогч юм.

Шинжилгээний ангийнхныг “Andersen, Meyer & Co”-ний Хүрээн дэх төлөөлөгч Франс А.Ларсон (Frans August Larson 1870-1957) зуучлан Богд хаанд бараалхуулжээ. Богд хаан судлаачдын хэрэг зорилгыг сонирхон, шинжилгээний ажилд нь анхаарал тавьж, газарч, хэлмэрч, унаа хөсөг зэрэг бүхий л талаар туслахаа амалсан байна. Зочдын сүүлд бичсэнчлэн Хүрээний Амьд Бурхан хутугт Эндрюсийн автомашиныг ихэд сонирхож байсан учир Франс А.Ларсон “Model-T Fords” загварыг түүнд бэлэг болгон өргөн барьж байжээ. Р.Ч. Эндрюс 1921 онд Нью Йоркт хэвлүүлсэн “Across Mongolian Plains” бүтээлдээ Богд хутугт, монголчуудын тухай сайхан сэтгэгдлээр бичсэний гадна Монгол нь америкийн капитал оруулах, түүхий эд олох чухал эх булаг болохыг ч тэмдэглэсэн байдаг. (2) Р.Ч.Эндрюсийн хайгуулын анги Монголд таван удаа ирж, шинжилгээний ажил хийх явцдаа Говийн нутгаас 100 гаруй сая жилийн өмнө амьдарч байсан эртний үлэг гүрвэлийн яс, өндөг зэрэг чулуужсан олдвор үлэмж хэмжээгээр илрүүлсэн нь тухайн үедээ дэлхий дахинд томоохон дуулиан шуугиан тарьжээ. Сайхь эрдэмтэд өөрсдийн ажлын үр дүнгээ олон боть ном болгон хэвлүүлсэн нь одоо ч эрдэм шинжилгээнийхээ ач холбогдлыг алдаагүй байгаа ажээ.

Р.Ч.Эндрюс Монголын Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн гишүүн проф. Ж.Цэвээнтэй олонтоо захидлаар харилцаж байсан бичиг баримт архивт хадгалагдаж байна. Ж.Цэвээнд 1926 онд Эндрюсээс ирүүлсэн нэгэн захидалд бичихдээ: “Манай шинжилгээний ангийн талаар өргөн тархсан шүүмжлэл бол Монголын Засгийн газраас гараагүй гэдгийг нотлон мэдэгдэж байна...Таны болон танай Засгийн газрын тухайд би туйлын сайхан сэтгэл өвөрлөж явдаг..Би хамаг амалснаа бүгдийг биелүүлэх эрмэлзэлтэй байгаа бөгөөд цуглуулга, номыг дөнгөж бэлэн болмогц Өргөө рүү явуулна гэдгийг батлан илэрхийлэх байна. Танд болон Монголын Засгийн газар ажилладаг бусад нөхөддөө гүн хүндэтгэл илэрхийлье” (3) гэсэн байв. Энэ нь Эндрюсийн шинжилгээний ангийг тагнуул туршуул гэж шүүмжилж байсныг үүнд монголчууд огт холбогдолгүй, харин Зөвлөлт Оросын явуулж буй ажиллагаа гэдгийг тэд сайтар ойлгож байсан хэрэг юм. Эндрюс тусгай албаны ажилтны бүртгэлтэй байсан нь түүний үндсэн ажил биш байсан гэдэг нь тодрхой билээ.

Р.Ч.Эндрюсийн судалгаа-шинжилгээний ангийн ажилд анхнаас нь Бээжин дэх АНУ-ын элчин сайд, доктор Паул С.Райнш⁴, Тяньжин дэх Ерөнхий консул Чарльз Д.Тенни (Charles Daniel Tenney), консул С.Ж.Фуллер⁵, Шаньхай дахь Ерөнхий консул Е.С.Куннингхем (Elliston S.Cunningham), худалдааны атташе Х.Арнольд нар онцгой анхаарч бүхий л талаар туслан дэмжиж байжээ. Эдгээр эрхэмүүд Гадаад Монголын нийслэл Өргөөд АНУ-ын Консулын газар нээхийн чухлыг Вашингтонд нэг биш удаа уламжилсаар байсан юм.

1915 оны Хиагтын гурван улсын Гэрээгээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хязгаарлаж, Хятадын хэмжээт эзэрхэл (suzerainete), Оросын хамгаалал (protectorate) дор автономит улс болж, тус орны дотоод, гадаад улс төрийн амьдрал ээдрээ төвөгтэй болсон, Европт дэлхийн I дайн эхэлсэн нь Хаан Оросын Алс Дорнод дахь нөлөө ялангуяа Монголд мэдэгдэхүйц буурсан нь Хятадын тийм нөлөө Монголд тэр хэмжээгээр өсөхөд хүргэж байв. Ийм түүхэн хүнд нөхцөлд Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын зэрэг нөлөө бүхий ноёд Америкийг түшиглэх санаа гаргаж Богд хааны дэмжлэг авчээ.

4 Dr. Reinsch, Paul Samuel (1869-1923) Милуаюк хотод герман-америк жүүд гэр бүлд төрсөн, хуульч, АНУ-ын улс төрийн шинжлэх ухааны анхны шилдэг профессоруудын нэг, дипломатч, 1892 онд Висконсин их сургуулийг бакалавр, 1894 онд мастер, 1898 онд докторын зэрэг хамгаалсан. 1898-1901 онд Висконсин их сургуульд дэд проф. 1901-13 онд профессор, 1912-13 онд Берлин, Лейпцигийн их сургуульд зочин проф. 1906, 1910 онд Пан Америкийн конгресст АНУ-ын төлөөлөгчдийн тэргүүнээр оролцож байсан. Хятадыг АНУ хүлээн зөвшөөрсний дараа Ерөнхийлөгч Б.Вильсон Рейншийг 1913 онд Дундад улсад суух АНУ-ын анхны элчин сайдаар томилж, тэрбээр 1919 он хүртэл ажиллажээ. Версалийн гэрээгээр Шаньдун мужийг Японд шилжүүлснийг шийдвэртэй эсэргүүцэж байв. Өргөөд Консулын газар байгуулах санал дэвшүүлж, мөн бусад дипломачдын саналыг бүрэн дэмжиж байжээ. Улс төрийн ШУ-ны шилдэг хорь гаруй бүтээл туурвиснаас заримыг дурдвал “World Politics at the End of the Nineteenth Century” (1900), “Intellectual and Political Currents in the Far East” (1911), “An American Diplomat in China” (1922), “Secret Diplomacy” (1922) болно.

5 Fuller, Stuart Jamieson (1880-1941) Айова мужийн Кеокүк хотод төрсөн. 1906-10 онд Хонгконгт дэд консул, 1910-11 онд Италийн Неполед дэд консул, 1911-12 онд Шведийн Готенбургт дэд, 1912-13 онд Перугийн Икюитост консул, 1913 онд Өмнөд Африкийн Дурбанд консул, 1919-23 онд Тяньжинд консулоор ажиллаж байв.

(4) Цогт гүн Бадамжап⁶ зэрэг зарим ноёд Америк улс хол оршдог, Японоос тусламж хүсвэл хялбар бөгөөд хурдан бүтнэ гэж байсан боловч Япончууд Солонгосыг хэрхэн эрхшээлдээ оруулсныг монголчууд нэгэнт мэдсэн байв. Жалханз хутугт нар Франс А.Ларсон лугаа урьдчилан санал солилцоход тэрбээр Америк баян, хүчирхэг, бага буурай улсыг тэтгэн дэмжих сонирхолтой, хэрэв Америк Монголыг дэмжвэл Хятадын Засгийн газар төдийлөн эсэргүүцэж зүрхлэхгүй хэмээж байжээ. Ийнхүү төлөөлөгчид 1919 оны өвлийн эхэн сард “А, М & Со”-ний машинаар Бээжин орохоор нууцаар мордож, өвлийн дунд сард Хүрээнээ буцаж иржээ.

6 Бадамжап, Цогто Гармаевич (1879-1937) 1913 онд Олноо өргөгдсөн Монгол Улсын Гадаад харилцааны сайд хошой чин ван М.Ханддоржтой Москвад танилцан нийслэл Өргөөд ирж, ГХЯ-нд орчуулагч түшмэл, ГХЯ-ны дэргэдэх монгол-орос хэл бичгийн сургуульд багшилж байв. Багад овогт тэрбээр Өвөрбайгалийн Тройцосавск тойргийн Глагольческ өртөөнд Хийгтын буриад албан хаагчийн гэр бүлд төржээ. Верхнеудинск (Улаан-Үд)-ийн гимназ, багш нарын семинар дүүргэсэн. Богд хаанаас гүн хэргэм хүртсэн. 1899-1901, 1907-1909 онд Т.К.Козловын удирдсан Монгол-Кам, Монгол-Сычуаний эрдэм шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд орчуулагч туслахаар ажилласан. 1902 оноос Хиагтад худалдааны “Собенников ба ах дүү Молчанов”-ын пүүст ажиллаж, Хятадын Ганьсу мужид дээрх пүүсийн төлөөлөгчөөр ажиллаж, Монгол, Манжуур, Дорнод Хятадад худалдааны жингийн цувааг удирдаж байв. Хаант Оросын ГЯЯ-ны зөвшөөрлийн жуух бичигтэйгээр 1907 оны хавар шинжилгээ явуулж, Өвөр Монголын Эзний голын ойролцоох орших Тангудын Хар хотын туурийг анх удаа малтан шинжилж, тайлангаа Эзэн хааны Газарзүйн нийгэмлэгт танилцуулсан нь чухал ач холбогдолтой үйл явдал болсон бөгөөд Оросын нийгэмлэг түүний энэхүү гавьяаг үнэлэн мөнгөн медалиар шагнажээ. Тиймээс ч эрдэмтэн Козловын хоёрдахь удаагийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд орж ажиллах боломж олджээ. 1910 оноос Дорнод Сибирийн Чита хотын Цэргийн захиргааны канцелярийн хэлтэст монгол хэлний орчуулагч, 1912 оноос «Нобель» худалдааны компанийн хэлтэст албан хаагч, дараа нь Өвөрбайгал дахь Хатан хаан Мариягийн ивээл доорх хүүхдийн асран хамгаалах төвд нийгмийн ажилтан, 1913 онд Итгэлт хамба тэргүүтэй Буриадын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж Санкт-Петербургт айлчилж, Романовын удамынхан Оросын хаан ширээнд заларсны 300 жилийн ойн арга хэмжээнд оролцжээ. Энэ үеэр Гадаад Харилцааны сайд хошой чин ван Ханддоржтой танилцан нийслэл Өргөөд ирж, ГХЯ-нд орчуулагч түшмэл, ГХЯ-ны дэргэдэх монгол-орос хэл бичгийн сургуульд багшилж байв. 1917 оны 2 дугаар сарын хөрөнгөтний хувьсгалын дараа Буриад Монголдоо буцаж, Өвөрбайгалийн нийгэм-улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болж, Өвөрбайгал, Эрхүү мужийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж Петроград айлчилж байв. 1917-18 онд Буриадын Үндэсний Хорооны гишүүн, Читад байгуулагдсан Пан монголын Түр Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж, түүний үйл ажиллагаанд мөн оролцож байв. 1920-нод оны эхээр Монголын улс төрийн нөхцөл байдал ээдрээ төвөгтэй болсон үед монголын нөлөө бүхий лам ноёдоод Японы талыг баримтлахын чухлыг ойлгуулахыг чармайж байсан юм. Ардын хувьсгал ялсны дараа 1921 оны 12 дугаар сараас Монголын Харилцан Туслалцах Хоршоонд хэсгийн даргын албыг хашиж, Хятадын олон хотуудаар худалдаа наймааны ажлаар явж байжээ. 1930 онд хувьсгалын эсэргүү ажиллагаа, пан монголын үйл ажиллагаанд оролцож байсан хэрэгт нэр холбогдож, тэрбээр Улаан-Үд рүү буцсан байна. 1931 онд дахин баривчлагдаж Новосибирскт 5 жил нутаг заагдан, дараа нь Ленинград дэдэм шинжилгээний ажил эрхэлж байгаад дүү Гомбын хамт Улаанбаатарт японы тал баримтлагч хувьсгалын эсэргүү бүлгийг удирдаж байсан хэрэгт баривчлагдан 1937 оны 12 дугаар сарын 15-нд хуулийн дээд хэмжээгээр шийтгэгджээ. Одоогийн Улаанбаатар хотын музейн байшин нь түүний амьдарч байсан байр юм.

Бээжинд хүрэлцэн очсон Жалханз хутагт нар АНУ-ын Хэргийг түр хамаарагч, доктор Чарльз Д.Теннитэй⁷ нууц уулзалт хийж, Богд гэгээний захидлыг гардуулан өгчээ. Захидалд АНУ-ын Засгийн газрыг Хүрээнд Консулын газраа хурдан нээвэл улс төр, худалдааны хамтын ажиллагаа ихэд хөгжинө гээд, захидлаа Орос, Хятадын Засгийн газраас нууж явуулсан болохоо ч дурджээ. (5) Сайхь уулзалт нь Монгол-Америкийн харилцааны түүхэнд болсон хамгийн анхны албан ёсны яриа хэлэлцээ байжээ.

1920 оны 4 дүгээр сард Тяньжин дэх Америкийн консул Чарльз Х.Эберхардт⁸ нийслэл Хүрээний байдалтай танилцахаар нууцаар ирж нөлөө бүхий ноёд хутугт нар лугаа биеэр уулзахад тэд аанай л Америкийн Консулын газрыг Хүрээнд хурдан байгуулахыг амаар хүсчээ. Дараа нь Жалханз, Дилав хутугт нар голлон Гадаад Монголын автономит эрхийг сэргээх шаардлагыг үндэслэн Богд гэгээний бичгийг шөнө дөл болтол боловсруулж, өглөө нь Богд гэгээний тамга даруулж, америк консулын буудалсан байранд очиж Жалханз хутугт бээр биеэр гардуулжээ. Сайхь бичиг дотор "...Америк улс өөрийн шууд хамгаалалдаа авах, Хятадын Засгийн газар сануулга өгөх, өөр бусад зохист аргаар Монголын асуудлыг зориуд анхааруулан монголчуудыг тэсвэрлэшгүй хүнд байдлаас ангижруулах ажаамуу" (6) гэсэн байв. Бүх ярианд хэлмэрчийн үүргийг Монголын гүн Франс А.Ларсон гүйцэтгэжээ.

1920 оны 4 дүгээр сарын 12-13-нд Хүрээн дэх "Mongolian Trading Company"-н төлөөлөгч А.М.Гуптилл, "Andersen, Meyer & Co.,"-ийн төлөөлөгч Ф.А.Ларсон нар мөн өөрсдийн санал, байр сууриа албан захидлын хэлбэрээр бичиж консул Эберхардтад гардуулжээ. Гуптилл бичихдээ: Монголд дурдсан хоёр компани Өргөөд шууд үйл ажиллагаа явуулж буй. "China American Trading Co," болон "China Java

7 Tenney, Charles Daniel (1858-1930), Бостонд төрсөн. 1878 онд Дартмоутын их сургуулийг бакалавр, 1879 онд Оберлины их сургуульд мастер, 1900 онд Дартмоутын их сургуульд хуульзүйн ухааны докторын зэрэг хамгаалсан, 1886-96 онд Тяньжинд дэд консул, дараа нь Тяньжинийн (Peiyang) их сургуулийг үндэслэгч бөгөөд анхны Ерөнхийлөгч, Хятадад дөрвөн жилийн дээд боловсролын системийн үндсийг тавигч, Ли Хун-жаны англи хэл, Өрнийн Шинжлэх ухааны хувийн багш, Бээжинд АНУ-ын Элчин Төлөөлөгчийн газарт зөвлөх, Элчин сайд Паул С.Райнш нутаг буцахад хэрэг түр хамаарагчаар ажиллаж байв.

8 Eberhardt, Charles Christopher (1871-1953) Канзас мужийн Салина хотод төрсөн. Салинад Канзасын их сургуулийн бизнесийн удирдлагын салбарыг төгссөн. Газрын тосны бизнес эрхэлж байгаад АНУ-ын Гадаад албанд орсон. 1904-06 онд Мексикод Дэд консул, Ерөнхий консулын орлогч, 1906-08 онд Перу улсын Икюнтос, 1908-10 онд Колумбын Барранкюлла хотод консул, 1910-11, 1921-24 онд Рио де Жанейрод Ерөнхий консул, 1919-1921 онд Тяньжинд консул, 1925-29 онд Никарагуа, 1930-33 онд Кости Рикод элчин сайдаар ажиллаж байжээ.

Exprot Co.,” Хаалганаас ажлаа явуулдаг, бид саяхан Хиагтад салбараа нээсэн, удахгүй Алтай хотод нээнэ, Монгол дахь Америкийн худалдаа жил болгон хоёр сая ам. доллараар өсч байна. Монголын үл мэдэгдэх газар нутагт Америкийн уул уурхайн синдикатууд үйл ажиллагаа явуулах өргөн боломж байна. “Монголор” уурхайн компанийн суурин захирал Барон Фиттингхофф (Resident Director Baron Fittinghoff) үйл ажиллагаа явуулж буй боловч ямар ч дэмжлэг тусалцаа байхгүй байгаа, большевикийн нөлөө орж ирж буй, хятадуудын хүнд суртал, тиймээс Америкийн “Int’l Banking Corporation”-ын салбарыг Өргөөд нээх, Өргөөд АНУ-ын Консулын газрыг нээхийн чухлыг дурдсан бол Ф.А.Ларсон бичихдээ: Өргөөд Америкийн Консулын газрыг нээхийн зайлшгүй нь нэгд. Улс төрийн нөхцөл байдал, хоёрт. Гадаадынхны эрх ашгийг хамгаалах, гуравт. Өсөн нэмэгдэж буй худалдааны үйл ажиллагаа эдгээр болно гэж онцлон дурдсан байв. Эдгээр хүсэлтүүд үнэхээр бодит байдалтай нийцэж байв.

Ч.Эберхардт консулын газартаа буцаж, Монголын талын бичиг, захидлыг Вашингтонд яаралтай хүргүүлж, дагалдах тайландаа бичихдээ: “Монголчууд сүлдхийморь, тэмцэх чадвараа алдсан үндэстэн угсаатан огтхон ч биш. Тэд ямар ч түрэмгийлэгчийн балмад үйлдлийн эсрэг зэвсэг барин дайтах хэмжээнд хүртэл эсэргүүцэн тэмцэж чадна. Монгол нь автономитоо сэргээн босгож, хамгаалахын төлөө нижгээд жилийн өмнө Оростой хамтарсаны нэгэн адил бусад улс үндэстэнтэй хоршин ажиллаж магад...гэхдээ Америк юм уу, Их Британи л шударга харилцана гэдэгт тийнхүү итгэн ивээлд нь орох хүсэлтээ тов тодорхой илэрхийлж байна...хэрэв Монголчууд зохих ёсоор зэвсэглэвэл тэд бээр зориглон хөдөлж автономоо сэргээн бататгаж чадахсан болов уу” (7) гэсэн байна. Монголчууд болон бусад нүүдэлчдийн талаар соёлт ертөнц тухайн үедээ төдий л өндөр сэтгэгдэлтэй байгаагүй байхад харин америк консул Эберхардт “...монголчуудын баатарлаг зориг, цэцэн мэргэнийг үзэж гайхсан...” ажээ. (8) Ч.Эберхардтын 5 хоногийн томилолт нь албаа хашиж байхдаа Өргөөд ирсэн АНУ-ын дипломат албаны анхны түшмэл байснаараа онцлог байсан гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

1920 оны зун Жалханз хутугт тэргүүтэй төлөөлөгчид хоёрдахь удаагаа Бээжин явахад Дилав хутугт бүрэлдэхүүнд нь оржээ. Дилав

хутугт энэ аяллын тухай дэлгэрэнгүй өгүүлэхдээ төлөөгчдийн чухал зорилго нь Монголын автономийг сэргээхэд Америкийн дэмжлэг олох явдал байсан гэжээ. Жалханз хутугт Бээжинд АНУ-ын элчин сайд* (элчин сайд Crane, Charles Richard⁹ байжээ Д.У), Дилав хутугт цэргийн атташетэй (assistant military attache, major Wallace C.Philion байжээ Д.У) тус тус нууц уулзаж ярилцан санал солилцжээ. Ф.Ларсон аль аль уулзалтад хэлмэрчээр оролцжээ. Америкийн дипломатууд Монголын саналыг Засгийн газартаа уламжлахыг амласан байна.

Монголын төлөөлөгчид мөн Хятадын Ерөнхийлөгч (1918-22 онд Бээжингийн Засгийн Ерөнхийлөгчөөр Сюй Ши-чань ажиллаж байв Д.У), албаны бусад хүмүүстэй уулзсан боловч ямар нэгэн нааштай үр дүнд хүрээгүй байна. Дилав хутугт үүний шалтгааныг төлөөлөгчдийн олонх Хятадын тал баримтлагчид, тиймээс үзэл бодлын талаар зөрүүтэй байсан учир нэгдмэл үйл ажиллагаа явуулах боломжгүй байснаар тайлбарлажээ. Мөн Жалханз хутагт Дамдинбазар энэ үеэр XIII Далай ламын бие төлөөлөгчөөр дамжуулан Их Британид захидал явуулж байсан мэдээ байдаг.

Хэрэв Америк улс дэмжлэг үзүүлэхгүй ахул Зөвлөлт Оросоос тусламж хүсэх санаа бодол Богд гэгээн, зарим ноёдод байсныг Дилав хутугт дурдсан байна. Иймээс тэд АНУ-д тавьсан хүсэлтийнхээ хариуг хүлээхийн зэрэгцээ Зөвлөлт Оростой хэлэлцээ хийх замыг нээлттэй байлгажээ.

1918 оны 1 дүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгч В.Вильсон энхтайван нөхцлийн тухай 14 зүйлт саналаа конгресст илтгэжээ. Энэхүү саналын үндсэн агуулга нь олон улсын далай тэнгист хөлөг онгоцуудын чөлөөтэй явах эрхийг хангах, тарифын саадыг арилгаж, чөлөөт худалдааг хөгжүүлэх, зэвсэглэлийг хорогдуулж, түүний баталгааг хангах, колончлолын асуудлыг алагчлалгүйгээр зохицуулах, Европын орнуудын хил хязгаарыг тодорхой тогтоох, хамгийн гол нь 14

⁹ Crane, Charles Richard (1858-1939) газрын тосны томоохон бизнес эрхлэгч, нэртэй араб судлаач. Ерөнхийлөгч Уильям Х.Тафт түүнийг 1909 оны 7 дугаар сард Бээжинд элчингээр томилон ажиллаж байсан боловч Төрийн нарийн бичгийн дарга Филандер Ноксын шаардлагаар 10 дугаар сард эгэж тагагджээ. В.Вильсоны сонгуульд томоохон хандив өргөсөн. Вильсоны шийдвэрээр 1917 онд Оростой дипломат холбоо тогтоох комиссыг тэргүүлж, Версалийн хэлэлцээрт оролцсон. 1921 оны 3 дугаар сард Ерөнхийлөгч Вильсон Чарльз Р.Крэнныг Бээжинд суух элчин сайдаар томилж, тэрбээр 1921 оны 7 дугаар сар хүртэл богинохон хугацаанд ажиллаж, бүрэн эрхээ элчин сайд Яков Г.Шурманд шилжүүлсэн. Тиймээс төлөөлөгчид Крэнтэй уулзсан байна. 1925 онд Нью Йорк дахь Дэлхийн бодлогын хүрээлэнгийн үндэс суурийг тавьжээ.

дүгээр зүйлд дурдсан бага буурай ба их гүрнүүдийн хоорондын тэгш эрх, улс төрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, эдгээрийн тусын тулд Үндэстнүүдийн Олон Улсын Холбоо байгуулах явдал байв. Энэ үед Европт дэлхийн I дайн Антантын ялалтаар дуусч, Версальд найрамдлын гэрээ байгуулагдаж, дараалан Парист энхтайвны бага хурал чуулахад В.Вильсоны 14 зүйлт санал гол мөрийн хөтөлбөр болсон байна.

«14 зүйл энхтайвны тунхаг» хэмээн нэрлэгдсэн шинэ санаачилгынхаа төлөө 1919 онд энхтайвны салбарт Нобелийн шагнал хүртсэн В.Вильсон (эдүгээ хүртэл докторын зэрэгтэй АНУ-ын цорын гагц ерөнхийлөгч юм Д.У) тэрбээр улс үндэстнүүдийн өөртөө засан тогтнох эрхийг амьдрал дээр хэрэгжүүлэхийг хичээж байсан ч дайны дараах асуудлуудыг шийдвэрлэх явцад үндэстэн ба колонийн асуудалд хариу олох нь тийм ч амар биш болохыг ухаарчээ. Томоохон колони эзэмшигч гүрнүүд болох Их Британи, Франц, Япон улс Парисын бага хурал дээр колонийн асуудлыг авч хэлэлцэхийг хүсэх ч үгүй байсан юм. Улс үндэстний өөртөө засан тогтнох номлолыг ямар ч үндэстнийг үл ялгаварлан хэрэгжүүлснээр 50 гаруй улсын хилийг дахин өөрчлөхөд хүргэж, ингэснээр энэ нь найрамдлыг тогтворжуулах хүчин зүйл бус, харин дэлхийн энхтайванд учирч болох аюул хэмээн тэдгээр гүрнүүд үзэж байжээ.

В.Вильсоны санаачлагын тухай Монголын дээдсийн хүрээнийхэн Ларсоноор дамжуулан сонсож мэдсэн ажээ. Тиймээс Монголын эрх баригчид холын АНУ-д хандаж Монголын автономийг сэргээх хэрэгт дэмжлэг авах, Өргөөд Америкийн Консулын газрыг даруй нээхийг шаргуй хүссээр байжээ. Харбинд хэвлэгдэж байсан “Вестник Азии” сэтгүүлийн газрын ажилтан, дорно дахинч М.Воллосович нийслэл Хүрээнд ирж Ерөнхий сайд Намнансүрэнгэй уулзаж ярилцахдаа: Вильсоны саналын дагуу “бусдын хараат биш, өөрийн тусгай эрхтэй” болох хүслээ Америкийн талд мэдүүлж, Монголын асуудлыг АНУ-ын Конгрессоор хэлэлцүүлэх талаар зөвлөж байсан тухай академич Ц.Пунцагноров бичжээ. (9) М.Воллосович удалгүй “У Соседей. Письма из Монголии” өгүүллээ “Вестник Азии” сэтгүүлийн №34-35-т нийтлүүлсэн байна.

Бээжин, Тяньжинд сууж байсан Америкийн консулынхан

большевизмын нөлөө, Сүй Шү-чжэний эзэрхийлэл зэргийг харгалзан түүнчлэн Америкийн худалдаа, улс төрийн ашиг сонирхолыг бодолцсон ч Гадаад ба Дотоод Монголын аль нэгт өөрийн консулын газартаа болох, ялангуяа нийслэл Өргөөд Консулын газар даруй нээхийг Вашингтонд тийнхүү нэг биш удаа санал болгосоор байжээ.

Консул Самуэл Сокобин, түүний Өргөө дэх томилолт

1919 онд Бээжин дэх АНУ-ын Худалдааны Төлөөгчийн газрын тэргүүн атташе Арнольд, консул Эберхардт нар Монголын улс төрийн одоогийн байдал нь Орос, Хятад, Японы улс төрийн тоглоом болж тун ээдрээтэй байгаа тул Хаалганд Консулын газар нээснээс Өргөөд нээх нь Америкийн эрхэм дээд эрх ашигт илүү нийцнэ гэж Вашингтонд анхааруулжээ. Бээжин дэх АНУ-ын Худалдааны яамны худалдааны комиссар А.В.Феррин (Augustin William Ferrin 1878-1940) мөн энэ тухай бичихдээ: “Монголчууд америкчуудтай маш элэгсэг дотно харилцдаг атлаа Орос, Япончуудаас ихэд болгоомжилдог. Америк орон эндээс хэт алсад орших учир өөрсдийг нь тоох хүн олддоггүй гэж боддог бололтой. Хэрэв Америк Өргөөд Консулын газраа нээвэл улс төр, худалдааны үлэмж нөлөө олохын зэрэгцээ энэхүү гайхамшигт орны ирээдүйн хөгжилд тун их тус хүргэх нэн чухал хүчин зүйл болохсон билээ” (10) гэжээ. Харин АНУ-ын элчин сайд Жонатан Эдлтон 2012 онд Улаанбаатарт хэвлүүлсэн сонирхолтой бүтээлээ дээрх Америкийн дипломатч Ферриний Төрийн департаментдээ илгээсэн илтгэлийн нэн чухал хүчин зүйл (a most helpful factor) хэмээх өгүүлбэрээр нэрлэсэн байна. (11)

Төв Азийн шинжилгээний ангийнхны тайлан, тэдний бичиж нийтлүүлж байсан өгүүлүүдэд ч дээрх санаа бодлууд тусгагдаж байсан юм.

Гэвч Богд гэгээнтний Засгийн газрын удаа дараагийн санал хүсэлтэд АНУ албан ёсны хариу өгөөгүй нь “нээлттэй хаалганы бодлого”-ын хүрээнд шинээр байгуулагдсан Хятадын БНУ-ын газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах байр сууриа үргэлжлүүлж байсныг харуулах бөгөөд мөн энэ бүс нутаг дахь Орос, Хятад, Японы нөлөөний хүрээгээ тодорхойлсон эл, далд элдэв гэрээ хэлэлцээрт АНУ орооцолдоогүй, мөн Монголын хэт алслагдсан

байдал, зах зээлийн хэт жижиг багтаамж зэрэгтэй холбоотой байснаар тайлбарлагдана.

Уг нь 1915 оноос Чуулалт Хаалган эсвэл Хүрээнд Консулын газар нээх тухай асуудал АНУ-ын Төрийн департаментэд нэг бус удаа ноцтой яригдаж эхэлжээ. Америкийн судлаач Алиша Кэмпийн судалснаар АНУ-ын Засгийн газар Монголын тусгаар тогтнох эрмэлзэл, түүнийг тойрсон улс төрийн элдэв яриа хэлцлээс тодорхой зүйл олж чадаагүй боловч, Эберхардтын илтгэлийг үндэслэн, тэгээд ч Хаалганд ч бай, Хүрээнд ч бай адилхан Хятадын нутаг дотор учраас Бээжин, Хүрээ хоёрын тэг дундаас Азийн төв болох хойд хэсгийн олон улсын байдлыг ажиглах “хаалга, цонх” байж болох үүднээс АНУ-ын Төрийн департамент 1920 оны 4 дүгээр сарын 17-нд Хүрээнд биш, Хаалганд Консулын газар нээх шийдвэр гаргасан байна. Тэгээд нилээд бэлтгэл ажил болж байж жилийн дараа 1921 оны 4 дүгээр сарын 1-нд Хаалган хотноо Консулын газраа нээжээ. (12)

Ардын Засгийн газар АНУ-тай харилцаагаа хөгжүүлэх томоохон сонирхол байсан бөгөөд энэ нь нэг талд тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх, нөгөө талд Дундад улстай харилцахад илүү нөлөө үзүүлж чадах АНУ-аар зуучлуулах явдал байжээ. Харин АНУ Монголыг Дундад улстай хэл амаа ололцсоны дараа л тусгаар тогтнолын асуудлыг нь хэлэлцэх, гэхдээ зуучлах саналыг идэвхтэй бөгөөд тууштай дэмжих чигтэй байсан нь дараа, дараагийн үйл явдлаас тодорхой болсон юм.

АНУ-ын Төрийн департамент Гадаад Монголын асуудлыг тухайлан хариуцсан суурин Консулын газрыг Хүрээнд биш, Хаалганд нээх урьдчилсан шийдийг Ерөнхий консул Чарльз Эберхардтийг нууц томиллолтоор Хүрээнд ирээд байх үед 1920 оны 4 дүгээр сарын 17-нд гаргажээ. Харин 1920 оны намар Төрийн департамент асуудлыг эцэслэн шийдвэрлэж, консулд (дэд) Пол Ж.Жеймсоныг¹⁰ томилж хэдийгээр тэрбээр Вашингтонд эмчлүүлж, эрүүл мэнд нь тэнхирч гүйцээгүй байсан ч уг томилогоог хүлээн авсан байна. Чингээд түүнийг түр томилжээ. Гэвч Төрийн департаментын Консулын Товчоо 1920 оны 11 дүгээр сарын 15-нд асуудлыг дахин хэлэлцээд Хятадын зүүн өмнөдод орших Шаньтоу хотноо дэд консулоор ажиллаж байсан Самуэл

¹⁰ Jameson, Jay Paul (1883-?) Колумбын тойрог Вашингтонд төрсөн. Хурдан бичээч, хятад хэлний мэргэжилтэн, 1909-10 онд Шаньхайд Ерөнхий консулын орлогч, 1910-11 онд Дэд консул, 1914 онд Уханьд Дэд консул, 1915-17 онд Наньжинд консулоор ажиллаж байжээ.

Сокобиныг Хаалганд консулаар (дэд) томилж, тэрбээр 1921 оны 2 дугаар сарын сүүлээр Бээжинд Хятадын ГЯЯ-наас үйл ажиллагаагаа явуулах зөвшөөрөл (exequatur) хүлээж авчээ. Харин Японы тал консул Сокобинд зөвшөөрөл олгохгүй байх талаар Хятадын Засгийн газарт шахалт үзүүлж байсан нь Америкийн сонирхолыг Монголд оруулахыг эсэргүүцэж байсны нотолгоо юм.

1921 оны 4 дүгээр сарын 1-нд Гадаад Монголыг тусгайлан хариуцсан АНУ-ын анхны суурин Консулын газар Хаалганд нээгдэв. Гол зорилго нь Америк-Монголын хооронд байнга өсөн нэмэгдэж байсан худалдааг бүх талаар хөхиүлэн дэмжих, худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөх, хамгаалахад туслалцаа үзүүлэхэд чиглэгдэж улс төрийн асуудал хоёрдугаарт тавигдсан байна. Ж.Арнольд, С.Фуллер, П.Рейнш нар Консулын газар байгуулахын зайлшгүйг чухамдаа хоёр талын худалдаа өсөн нэмэгдэж байгаа тул өөрийн талын эрх ашгийг хамгаалахтай холбогдуулан Вашингтонд саналаа идэвхтэй тавьж байсан юм. Бээжин дэх худалдааны атташе Ж.Арнольдын сүүлийн үеийн тооцоолсноор Монголын экспортын нэр төрөл 70 мянган адуу, 30 мянган тэмээ, 10 мянган үхэр, 2 сая хонь, үлэмж хэмжээний ноос, арьс шир, ангийн үс, Хаалган-Хүрээний худалдааны эргэлт 15 сая тээлээр (хятад зоосон мөнгөний нэгж буюу лан) хэмжигдэх болжээ.

АНУ-ын Засгийн газар Сокобиноос Гадаад Монголын тухайд нүдээр харсан илтгэл (eyewitness report) шаардаж байсан учир тэрбээр Өргөө явах бэлтгэлээ хангах ажилдаа орсон байна. Тухайлбал Хүрээн дэх Барон Унгерний үйл ажиллагаа, Японы дэмжлэг, Хүрээний Засгийн газар, большевикуудын байр суурь, төлөвлөгөө, Хүрээ-Хаалганы хоорондох 600 бээр газарт цахилгаан тээврийн ажиллагааны нөхцөл байдал, америкийн компаниудын хохирол зэрэг олон асуудал багтаж байв. С.Сокобин юуны өмнө Бээжин орж ЭСЯ-ныхантай уулзаж, Цэргийн дэд атташе Уоллес С.Филионоос Барон Унгерн, атаман Семёнов, хятадын цэргийн ухралт, манжуур дахь цагаан орос, хятад цэргийн үйл ажиллагааны талаар 12 багц тагнуулын мэдээлэл авчээ. С.Сокобин Харбинаар дайран 5 дугаар сарын 4-нд Тяньжинд Ерөнхий консул С.Фуллертэй уулзаж, Монголтой худалдаа хийдэг зургаан пүүсийн төлөөлөгчидтэй уулзахад “Standard Oil Company” Хүрээнд лаа, гэрлийн тос, шатахуун борлуулсны үнэ 30 мянган ам. доллар,

“Eitington-Schild Co.”-ийн захирал Ж.В.Берелсон Өргөөд 85 мянга 500 ширхэг тарвага, 11 мянган хэрмийн арьс үлдсэн, өөрийн пүүсийн төлөөлөгч оросын жүүд амь үрэгдсэн, “Andersen, Meyer & Co”-ийн мөн Өргөөд их хэмжээний ноос, ангийн үс үлдсэн, “Brenner Brothers” пүүсийн 45 мянган ам. долларын үл хөдлөх хөрөнгө, арьс шир, ангийн үс зэргээ алдсан тухай ярьжээ. С.Сокобин 5 дугаар сарын 6-нд Харбинд ирж “Mongolian Trading Company”-ийн ажилтан С.Х.МакЛаухэлмтай (S.H.MacLauhelm) ярилцахад 4 дүгээр сарын 16-нд Хүрээнээс орос бус гадаадынхны хамт гарч явсан, Унгерний цэргийн удирдлага америкчууд болон Өргөө хотын төлөөх орос, хятадын байлдаанд төвийг сахисан гадаадынханд 3 машин дайчлан гаргаж өгсөн тухайгаа ярьсан байна.

Төрийн департамент Чуулалт-Хаалган (Kalgan-Zhangjiankou буюу Жанчхүү) хотноо Гадаад Монголыг тусгайлан хариуцан суусан Америкийн анхны суурин консул (дэд) Самуэл Сокобин 4 сар гаруй хугацаанд судалгаа хийж бэлтгэл хангаж сая Ардын эрхт засаг тогтсоны дараа авто хөсгөөр говь цөлийг хоёр хоногт туулан Ф.А.Ларсоны хамт 1921 оны 8 дугаар сарын 18-нд нийслэл Хүрээнд анх удаа хүрэлцэн иржээ. Тэрбээр залуу хүн боловч консулын албыг 5 жил хашсан хятадын мэргэжилтэн байв.

Америк консул энэ албыг хашиж байсан хугацаандаа Хүрээнд дөрвөн удаа ирж байсан ба анхны аялалаараа Хүрээнд нэг сар байж, Ардын Засгийн газрын Ерөнхий сайд бөгөөд Гадаад хэргийн тэргүүн сайд Д.Бодоо, Дотоод хэргийн тэргүүн сайд да лам Пунцагдорж, Хэмжээт Цаазат хаан VIII Богд Жавзундамба хутугт зэрэг өндөр албаны хүмүүстэй уулзсан байна. Үүнийг Хүрээний байдалтай танилцсаны дараа сая 9 дүгээр сарын 12-нд Д.Бодоо хүлээн авч уулзан хэлэлцэхдээ Монголын үндэсний ардчилсан хувьсгал ялсны дүнд Ардын эрхт, Хэмжээт Цаазат засаг тогтсон үнэнхүү учир байдал хийгээд түүний гадаад, дотоод бодлогын тухай тайлбарлахын хамт өөрийн нэрийн өмнөөс АНУ-ын Гадаад хэргийн Төрийн нарийн бичгийн даргын

(Энэ үед Хюкес, Чарльз Еванс ажиллаж байжээ¹¹) нэр дээр илгээх ноотыг ноён консулд гардуулжээ.(13) Тэрхүү ноотод «...*Америк улсын Гадаад хэргийн яамны эрхэм сайд танаа...ард олноор туйлын гашуун зовлонг эдэлсэн ба одоо нэгэнт хятадын харгис цэрэг ба оросын муу хулгай барон унгерний зандалчин цэргийн хорлолоос ангижирч, Богд хаан эзнээ хэвээр ширээнээ залж, ардын эрхтэй засгийн газар байгуулан, улсын дотоод хэргийг сайжруулан засаж, гадаадтай найрамдахыг эрмэлзэж бүхий элдэв учрыг сая нэгэнт тунхаглан зарласан тул...Одоо гагцхүү тусгаалан илтгэх нь манай Богд хаан ба Засгийн газар хийгээд олны санал улсын Засгийн газраас манай Монголын Ардын Засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайд суулгаж, худалдаа, арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсч байгаа тул эрхэм сайд Та толилж даруйхнаа баяртай хариу хүртээх ажсаамуу» (14) гэжээ. Хуучин түүх бичлэгт энэхүү ноотыг Америк руу яаж илгээсэн нь тун бүрхэг байсан юм. Энэ ноот бичгийг ажиглахад Ардын Засгийн газар Богд хаан эзнээ хэвээр ширээнээ залсан явдлыг өөрийн улсын гадаад харилцааны асуудал дээр уян хатан дипломат аргаар ашиглаж байсан нь харагддаг. Түүнчлэн Д.Бодоо америк консулд МАН-ын мөрийн хөтөлбөр «*Эрмэлзэх Арван зүйл*»-ыг мөн гардуулсан нь англи орчуулгын хамт АНУ-ын Үндэсний архивын сан хөмрөгт хадгалагдаж байна.*

Ноён С.Сокобин Ерөнхий сайдтай уулзахдаа Монгол Улс тусгаар тогтсоноо албан ёсоор нотолж, гадаад олон улсуудад ялангуяа Дундад иргэн улсад тунхаглан зарлах нь чухал болохыг зөвлөсөн бололтой баримт юм. Үнэхээр ч уулзалтын хоёр хоногийн дараа, өөрөөр хэлбэл 9 дүгээр сарын 14-нд Ерөнхий сайд бөгөөд Гадаад хэргийн тэргүүн сайдын нэрийн өмнөөс *Монгол улсыг тусгаар тогтносон тухай*

11 *Charles Evans Hughes* (1868-1948), Мэдисон, Броун, Колумбын их сургуульд суралцсан, улс төр судлаач, хуульч мэргэжилтэй, профессор, БНН-ын гишүүн. 1907-10 онд Нью Йорк хотын 38 дахь амбан захирагч, 1910-16 онд АНУ-ын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, 1908 онд Уилльям Х. Тафт Ерөнхийлөгчийн үед дэд ерөнхийлөгчид өрсөлдөж байсан. 1916 онд Ерөнхийлөгчийн сонгуульд Вудро Вильсонтой өрсөлдөж байв. 1930-41 онд Шүүх яамны сайдын албыг хашиж байжээ. АНУ-ын Ерөнхийлөгч В.Ж. Хардингийн (Warren G. Harding) үед 1921 оны 3 дугаар сараас 1925 оны 3 дугаар сар хүртэл Гадаад хэргийн Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байх үед 1921 оны 9 дүгээр сарын 12-нд Хэмжээт цаазаг Монгол Улсын Ардын Засгийн газрын Ерөнхий сайд бөгөөд Гадаад хэргийн тэргүүн сайд Д.Бодоо Хаалган хотноо суусан Америкийн анхны консул Самуэл Сокобинтой нийслэл Хүрээнд анх уулзаж, АНУ-тай худалдааг хөгжүүлж, элчин харилцаа тогтоох тухай ноот болон Богд гэгээний тусгайлсан захидал тэргүүтнийг Хаалганаас Төрийн нарийн бичгийн дарга Хюгесийн нэр дээр илгээж байжээ. Түүнийг АНУ-ын Гадаад хэргийн Төрийн нарийн даргаар ажиллаж байхад 1921-22 оны Вашингтонд болсон олон улсын бага хурлаас Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах тухай онцлон тэмдэглэж байсан юм.

гадаад олон улсуудад тунхаглан зарласан бичиг-ийг дэлхий дахинд зарлажээ.

Ноён консул мөн сардаа Богд Жавзундамба хутугт лугаа бараалхжээ. Уулзалтын үеэр Богд гэгээн бас АНУ-ын Засгийн газарт тусгай бичиг гардуулж, миний бие хүн амьтан бүхний сайн сайхан, энхтайван, найрамдал, нөхөрлөлийг эрхэмлэдэг хэмээн дурдаад АНУ Монголын тусгаар тогтнолыг Хятадын талаар хүлээлгэн зөвшөөрүүлэхэд зуучлан өгч дөхөмийг үзүүлмүү хэмээн хүссэн байна. Тэрхүү бичгийг сийрүүлбэл дараах мэт. **“Хутугт би шарын шашны эзэн бөгөөд Монгол улсын хаан болох тул улстөрийн тухайн хэргийг миний Засгийн газар лугаа хэлэлцэх буй за. Шашин, амьтны тухай миний бие төрөлхөөс амьтан бүхнийг энэрэн үзэх зохистой тул Дундад Иргэн улс манай Монгол хоёр харилцан дайсан бололцож, олон амьтанг зовоохгүй эв найрамдал дотор учраа ололцохыг үнэнхүү хүсэх тул эрхэм Мэй улсын төлөөлөгч манай хоёр этгээдийн олон түмний ард амьтны тус дор аль болохоор хэлэлцэхийг хичээх болов уу”** хэмээсэн байв. (15) Бүх уулзалтад Ларсон орчуулагчаар оролцжээ.

Эдгээр бичиг баримтуудыг орчуулга, тайлбар, илтгэлийн хамт Вашингтонд даруй илгээжээ. С.Сокобин Засгийн газартаа Монголын улс төр, эдийн засгийн төлөв байдал, монголчуудын санаа бодлыг ойлгуулахад нэлээд түвэгтэй байсан бололтой. Ямар ч байсан тэрбээр монголчууд бол ерөөс хятадууд биш, огт өөр улс үндэстэн мөн гэсэн түрүү үеийн зарим америк жуулчдын санал дүгнэлтийг дахин нотлон мэдээлж байжээ. Америк консул Монгол, Оросын харилцааны тухай илтгэлдээ бичихдээ: “Большевикуудын гол зорилго нь Монголын олон ардыг чөлөөлөхөд байсангүй, харин өөрийгөө Хятадаар хүлээн зөвшөөрүүлж, худалдааны харилцаагаа өргөтгөх, хувьсгалын эсэргүү цагаан оросуудыг эргүүлэн авах тухай Хятадын Засгийн газартай хэлэлцээ хийхэд Монголоор дэнчин тавьж ашиглах явдал байв” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. С.Сокобин Хүрээнд байхдаа монголчууд америкчуудад тун сайн хандаж байна, Америкийн капиталыг Ардын Засгийн газар дэмжих юм байна гэсэн сэтгэгдэлтэй Хаалган хотноо буцаж очоод америкийн үйлдвэр, худалдааны хүрээнийхэнтэй уулзаж, Монголд хөрөнгө оруулах нь ашигтай хэмээж байжээ.

Ноён консул Хүрээнээс буцсаны дараа Монгол, Америкийн

хооронд улс төр, эдийн засгийн харилцааны нааштай нөхцөл бүрэлдэж эхэлсэн боловч Вашингтоны эрх баригчид мөн л болгоомжлон Монголын талын хүсэлтэд албан ёсоор хариу өгсөнгүй, харин өөрийн дипломатчдаа цаашдаа зөвхөн Хятад, Орос, Алс Дорнодын БНУ-тай Монгол Улс ямар чиглэлээр харилцаж байгаа талаар тодорхой мэдээлж байх заавар өгчээ. Энэ үед Бээжинд шинээр томилогдон ирсэн Элчин сайд Яков Г. Шурман¹² ЭСЯ-ныхаа хүлээн авалтан дээр “АНУ Дундад улсын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг таслан хуваахад хүрвээс үл хүлээхүй хэмээмэй” (16) гэж мэдэгджээ. Эндээс нэг зүйлийг ажигдахад АНУ-ын Бээжин дахь ЭСЯ болон Хаалган дахь Консулын газрын Монголын талаарх байр суурь ялгаатай байсан бололтой байдаг. Тиймээс Вашингтон шийдвэр гаргахдаа Бээжингээс ирж байсан мэдээлэлд илүү тулгуурлаж байсан байж болох талтай.

С. Сокобины Хүрээнд ирсэн ажил явдлын талаар Зөвлөлт Орос Улс дээд түвшинд мэдээлэлтэй байжээ. ЗОУ-ын Засгийн газар Алс Дорнод дахь олон улсын байдал ялангуяа Сибирийн аюулгүй байдлыг хангах үүднээс 1920 оны 4 дүгээр сард Алс Дорнодын БНУ-ыг байгуулжээ. Энэ улсын ГЯЯ-ны анхны сайдаар Б.З.Шумяцкий томилогдон ажиллаж байгаад ажлаа И.Л.Юринд хүлээлгэн өгөөд 1921 оны эхнээс ЗОУ-ын Гадаад Хэргийн Ардын Комиссариатын Сибирь ба Монголын асуудал хариуцсан Бүрэн эрхт төлөөлөгч, Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газрыг толгойлж байх үедээ тэдгээр мэдээллийг Москвад дамжуулж байжээ. Тэрээр 1921 оны 9 дүгээр сарын 22-нд Г.В.Чичеринд илгээсэн цахилгаан утсандаа”... Нийслэл Өргөөд ирсэн Америк консул Монголын хувьсгалт Засгийн газрыг улс орноос нь салгаж хөндийрүүлэх, манай нөлөөг устгах зорилгоор ноёд, лам нарыг нэгтгэн нягтруулахын тулд сар гаруй чармайн ажиллаж байна. Монгол, Хятадын хооронд Америк улс зуучлах мандатыг олж авахын тулд тэрбээр Вашингтоны эрх баригчдын өмнөөс улиглан гуйж, чингэвээс эдийн засгийн тусламж үзүүлнэ гэж амлаж буй. Нийслэл Өргөөд намайг очихоос өмнө Америк консул Богд гэгээнд нөлөөлөн амжиж, түүгээр дамжуулан Монголын Засгийн газарт

12 Schurman, Jacob Gould (1854-1942) Канадад төрсөн. 1977 онд Лондоны их сургуульд В.А, 1878 онд М.А, 1878-80 онд Парис, Берлинд суралцсан. 1886-92 онд Корнеллын их сургуульд проф. 1892 оноос Корнелл их сургуулийн Ерөнхийлөгч, 1899 онд АНУ-ын Филиппиний Анхдугаар Комиссын тэргүүн, 1912-13 онд Грект, 1921-25 онд Хятадад, 1925-29 онд Германд элчин сайдаар ажиллаж байжээ.

нөлөөлөхийг оролдож байна. Тэрбэр феодал-теократ этгээдээс голлон бүрэлдсэн олон нийтийн зүтгэлтнүүдийн зөвлөлгөөн гэгчийг зарлан хуралдуулж, америкчууд түүнд тулгуурлан ажиллахыг хүсч байна.” (17) гэжээ. Б.З.Шумяцкий удалгүй Монголын төлөөлөгчдийг Москвад байхад 1921 оны 11 дүгээр сарын 2-нд В.И.Ленинд дараах захидлыг илгээсэн байна. Үүнд “Нийслэл Өргөөнөө сүүлийн үеэс америк, япон хүмүүс үзэгдэх болж, мөнгө, санга, бараа таваараар далимдуулан монголд “найрамдлаа” тулган хүлээлгэх гэж ихэд хичээж байна. Гэвч Монголчууд бидэнтэй тогтоосон найрамдалт харилцаандаа үнэнчээ илэрхийлэн, Богд гэгээн хүртэл (мэдээжээр олон нийтийн санаа сэтгэлийг дагаж) Хятадаас ирсэн Америк консулын улиглан ятгасны хариуд “төрийн хэргийн талаар манай Засгийн газартай ярилцана уу” гэж бичгээр хариулжээ. Өөрөөр хэлбэл, эрх баригч Ардын хувьсгалт намтай ярилц гэсэн үг юм...Эл нам өөрийгөө Коминтернийн гишүүн гэж үзээгүй юмаа гэхэд юу ч атугай “Коминтернийн үнэнч нөхөр” гэж үздэг юм” (18) гэжээ. Гэтэл Сокобины Хүрээн дэх томилолт Шумяцкийн сүржин мэдээлсэн шиг зорилготой байгаагүй юм.

Консул Самуэл Сокобин Хүрээнд анхны томилолтоор ажилласныхаа дараа 1921 оны намар Вашингтонд илгээсэн нууц тайландаа: Москвад Монгол-Зөвлөлтийн хооронд бие биеэ харилцан хүлээн зөвшөөрөх тухайд нууц хэлэлцээ явагдаж байгааг тэмдэглээд, энэ үеэр большевикууд Гадаад Монгол дахь хуучин оросын бүх өмч, хөрөнгийг өөрийн мэдэлд авах асуудал тавигдаж байгаа бололттой, тиймд “Монголор”-ыг өөрийн улсын “Peking Mongolor Co.”-г лизингээр худалдан авахын чухлыг анхааруулсан байна.(19) Сокобин өөрөө “Peking Mongolor Co”-ийн нэрийн өмнөөс Сангийн яамны удирдлагатай Монголд алт олборлох концессын шинэ хэлэлцээ эхлүүлж, С.Данзан үүнд нь ач холбогдол өгч байсан боловч орос зөвлөх Бутин саад учруулж байжээ. Тиймээс Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Цэрэндоржийн дэмжлэгт найдаж байсан байна.(20)

Америкийн судлаач, дипломатч Алиша Кэмпи ноён С. Сокобины эхний айлчлалын талаарх мэдээлэлд “Төрийн департамент шуурхай хариу өгч АНУ Монголын Ардын эрхт Засгийн газрыг эртхэн хүлээн зөвшөөрөх боломжийг алдсан байна” гэж дүгнэжээ.

Мөн үеэр С.Сокобины айлчлалын тухай МАН-ын ТХ, Ардын

Засгийн газрын төв хэвлэл «Уриа» сонины 1922 оны 11-15 дугааруудад “Монгол, Америк хоёр улсын тухай” нэртэй томоохон тайлбар өгүүлэл цувралаар нийтэгдсэн байна.(21)

Түүнд бичихдээ: “...хэдийгээр ЗОУ лугаа найрамдлын болзоо зүйлийг тогтоосон боловч манай улсын гадаадтай холбогдсон асуудал бүрнээ түвшрэв гэж итгэмжилж үл болно гэж манай удирдах ажилд оролцож байгаа цөөн хүн үзэж байна. Тэдний бодлоор, Америк улс их шударга, түүний нутаг орон манай улсаас алсалсан хол орших тул биднийг яавч эзэрхэхгүй гэж таамглан, түүнийгээ баримтлан америктай тусгайлан хэлэлцээ үүсгэх бодлоготой байв. Тийм бодлого нь үнэн хэрэгтээ үлэмж алдаж байгаа ноцтой төөрөгдөл мөн. Эзэрхэг түрэмгий улсууд хэзээ ч бага буурай улсын хүнд хэцүү байдлыг ухварлаж тусалж дэмжиж байсан удаагүй. Буурай орныг хэзээ ямагт эзэрхэн залгих бодлого явуулж байдаг нь тэдний тогтсон зуршил болжээ. Үүнийг америкийн империалистуудаас өнөө үед Хятадын талаар явуулж байгаа түрэмгий бодлого гэрчилж байна. Ийм байж Америк Монголд туслах нь юу л бол...урьд Монгол оронд хамгийн хүнд хэцүү үе тохиолдоход монголын зүтгэлтнүүд тусламж гуйж энэ орны төлөөлөгчдөд хандсан боловч ямар ч дэмжлэг үзүүлээгүйгээр үл барам хариу өгөөгүй...Хэрэв эзэрхэг улсуудыг цөөвөр чонотой зүйрлэвэл америкийг зэрлэг догшин арслан бартай зүйрлэж болно. 1921 оны эцсээр америкийн Вашингтон хотод болсон том хөрөнгөтөн улсуудын хуралд америк тэргүүлэн Алс дорнодын газрыг хуваарилан эзэрхэх асуудал хэлэлцсэн явдал түүний хэзээний шунахай бодлогыг харуулав. Тэр дээр Вашингтоны хуралд монгол, манж газрын баялаг, уурхай болон ашиг хөрөнгийн зүйлийг олон гүрнээр эрхлүүлэн зохицуулбал зохино гэж заасан явдал үүнийг давхар гэрчлэв. Эрхүү хотноо хуралдсан Алс Дорнодын улсуудын хуралдаан бол Ази тивийн ард түмнийг хуваан залгих гэсэн Вашингтоны эзэрхэг харгис этгээдүүдийн эрмэлзлийг няцаах, ард түмний ашиг тусыг хамгаалахтай холбогдсон асуудал хэлэлцжээ гэсэн байна. «Уриа» сонин цааш нь бичихдээ: америкийн империалист түрэмгий бодлогыг тайлбарласан явдал ерөөсөө энэ том хөрөнгөтөн оронтой ямар ч харилцаа тогтоохгүй гэсэн хэрэг биш бөгөөд хэрэв Америк улс Монголын талаар хоцрогдсон үзэл бодлоо өөрчлөх юм бол энэ улстай ердийн харилцаа тогтоож болох байна. Ийм ч учраас

Америкийн Засгийн газарт Монголын Засгийн газар анхаарал бичиг явуулж, Америкийн консулыг манай нийслэлд ирэхийг зөвшөөрч, хүлээн авсан юм гэж уг өгүүлэлд дурдсан байна.

С.Сокобин 1922 оны 1-2 дугаар сард Вашингтоны заавар ёсоор дахин нийслэл Хүрээнд ирж судлагааны ажлаа Ф.А.Ларсонгүйгээр хоёр сар үргэлжлүүлжээ.(22)

Түүний энэ удаагийн аяллын зорилго нь Ардын эрхт Засгийн газрын урьд нь уулзаж байсан удирдлагуудтай тогтоосон харилцаагаа лавшруулах, большевик Оросын ивээл доорх Монголын Засгийн газрын гадаад, дотоод бодлогын чиг хандлага, Монгол дахь Оросын нөлөө хэр байгаа, Монгол, Хятадын харилцааны шинж байдал зэргийг тандан мэдэх явдал байв. Америк консул Төрийн департаментэдээ уламжлахдаа Оросын нөлөө Монголд улам бүр лавширч, тэдний дэмжлэг авсан залуу хувьсгалчид нэгжгээд сарын өмнөөс эрх мэдлийг олж, хүчийг олоод Богд гэгээн, хутугт, ноёдын эсэргүүцэлтэй тулгарсан авч Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Бодоо, Дотоод яамны сайд да лам Пунцагдорж нарыг огцруулж, засгийн эрхийг үндсэндээ өөрсдийн гарт оруулж чадсан гээд Зөвлөлт Оросын Засгийн газар Монголыг тусгаар тогтносон улс хэмээн хүлээн зөвшөөрч гэрээ хэлэлцээр байгуулсан атлаа өөрийгөө Хятадаар зөвшөөрүүлэхийн тулд өөрийн цэргийг Монголоос татан гаргаж Монголыг Хятадад эгүүлж өгөх тухай хоёр нүүрт бодлого явуулж байна гэжээ.

Цагаан ордны удирдлага болон үйлдвэр, худалдааны хүрээнийхэн Монгол дахь алтны уурхайг багагүй сонирхож байсан учраас ноён С.Сокобин дунд тушаалын зарим түшмэдүүдтэй уулзаж уул уурхайн болон худалдааны талаар санал солилцжээ. Тэрбээр гуравдахь удаагаа 1922 оны 5 дугаар сард Хүрээнд иржээ. Энэ удаа С.Сокобин америкийн “Mongolian trading” пүүсийн Хүрээн дэх салбарын түшмэл Роберт Н.Уилльямсийн хүсэлтээр Монголд хүрэлцэн ирсэн байна. Учир нь “Mongolian trading” пүүсийн нэгэн чех ажилтанг Бээжинд ажлаар очоод байхад нь улстөрийн хэрэгт холбогдуулсан учир тэрбээр Монголд ирэхээс татгалзжээ. Тиймээс хотын захиргаа Уилльямсийг тэр хэрэгт нь барьцаалан хорьжээ. Энэ асуудлаар америкийн дипломатч өөрийн иргэний эрх ашгийг хамгаалах үүднээс хоёр долоо хоногийн турш янз бүрийн тушаалын хүмүүстэй уулзаж ярилцсаны дотор Цэргийн яамны

сайд Д.Сүхбаатартай гурван ч удаа уулзсан боловч суллуулж чадаагүй ажээ. С.Сокобин энэ байдлыг большевикуудын аюулаас хамгаалахын явуулга гэж үзээд Хаалган руугаа буцжээ. (23)

Түүний дөрөвдэх удаагийн аяллын тайлангаас үзвэл 1922 оны зун хувьсгалчдын дотор зөрөлдөөн гарч Ерөнхий сайд агсан Бодоо, да лам Пунцагдорж нарын 13 өндөр албан тушаалтан хувьсгалын эсэргүү хэрэгт холбогдож цаазлагдсан, түүний учир холбогдлын тухай байв. Зөвлөлт Оросын талыг барьсан залуу хувьсгалчид болон хуучин үеийн сурвалжит язгууртан, хутугт нар Дундад улстай зөвшилцөн тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх гэснийг нь Зөвлөлтийн эсрэг явуулга, хувьсгалын эсэргүү хэрэг хэмээн үзэж, тийнхүү хэлмэгдүүлсэн байна гэжээ. Үнэндээ ч олон талаар тийм байсан юм. С.Сокобиныг сүүлийн удаа мөн оны намар Монголд ирэхэд нь түүнийг хувьсгалын эсэргүү этгээдүүдтэй хуйвалдан сүлбэлдэж байсан хэмээн хардаж сэрдэн энэ тухай төвийн монгол, орос сонин хэвлэлээр муучлан бичиж, бүр *persona non grata* (итгэж үл болох этгээд) хэмээн түүнийг дахин ирвэл аюулгүй байдлыг нь хангаж чадахгүй гээд ер нь америкаас ирсэн ямар ч хүнд итгэж болохгүй гэж албан ёсоор зарлаж байжээ. Энэ бүх үйл ажиллагаа нь большевикуудын хийсэн ээлжилт тоглолт байсан болох нь өнөөдөр ойлгомжтой болсон билээ. Үйл явдал өрнөж байх зуур ЗОУ өөрийгөө Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх ил, далд явуулга хийж байсан бөгөөд Монгол-Хятадын харилцаанд зуучлах мандатыг алдахгүйг хичээж байв.

Үүнээс улмаас Вашингтоны удирдлага 1922 оны 12 дугаар сарын 4-нд ноён С.Сокобинд Монгол большевикуудын хяналтад байсаар байгаа тохиолдолд Хүрээнд дахин очиж үл болохыг анхааруулаад, харин Хаалган хотоос ажиглалтаа үргэлжлүүлэхийг үүрэг болгосон байна. Тэрбээр 1923 оны төвдөө илгээсэн нэгэн илтгэлдээ Цэргийн яамны сайд Д.Сүхбаатар хэрхэн таалал төгссөн тухай бичээд түүнийг “Монголын большевикуудын дотроос хамгийн гарамгай нь бөгөөд маш их эрч хүчтэй байсан, тэр ямар ч боловсролгүй, харин их үндэсний үзэлтэй, Хятадыг онц ихээр таалдаггүй нэгэн” (24) хэмээн тодорхойлжээ.

1923 оны 7 дугаар сард Бээжин дэх АНУ-ын ЭСЯ-ны Цэргийн атташе, дэслэгч (дэд Д.У) хурандаа, Жозеф Бернардын (Lieutenant)

tenant-Colonel Joseph H. Bernard 1877-1945) туслах, хятад хэлний мэргэжилтэн, ахмад В.Вудбриж (captian Woodrow Woodbridge) ан ав хийхээр Хүрээнд 2 долоо хоногийн хугацаагаар Ч.Эндрюсийн хамт иржээ. Тэрээр Сокобинд мэдээлэхдээ: Засгийн газар нь ерөнхийдөө улс орноо удирдаж буй ч Оросын консул (Бүрэн эрх барих элчин төлөөлөгч Д.У) (Н.М.) Любарский “гол шийдвэр”-ийг гаргаж байна. Нийслэлд оросын сайн зэвсэглэсэн, дэг журамтай цэрэг байрлаж байна гэжээ. Вудбриж Ерөнхий сайд Жалханз хутугтыг нас барсны дараа ирсэн бөгөөд хутугтыг большевик зөвлөгч нартай эн тэгш харилцах гэж байсан нь бүтэлгүйтсэн тухай мэдээлсэн байна. Сокобин хутугтыг “хүч чадавхи, эр зориг сул хүн” гэж дүгнэсэн байдаг. Энэ жил сар гаруй хугацаанд Хүрээ хийдийн 50 гаруй лам нар баривчлагдсан гэнэ. Амьд Будда Богд хаан өөрөө олон лам нарыг халсан ажээ. Хятадуудыг ч нутагт нь буцаасан байна. Аюулгүй байдлыг нь хангаж байсан Дотоодыг хамгаалахын дарга буриад ноён Батрон (Балдандорж А.Кэмп) ярилцахдаа тусгаар тогтносон Монгол Улсад Америкийн консулын газар яагаад анхаарлаа хандуулдаггүй байна хэмээн асууж байсан нь анхаарах зүйл гэжээ.

1924 оны эхээр консул С.Сокобин удирдлагадаа хоёр ч дэлгэрэнгүй мэдээлэл илгээсний дотор Монголын Засгийн газар тоглоомын шинжтэй болж байгаа учир нь залуу хувьсгалчдын тусгаар тогтнолын тухай гэнэн мөрөөдлийг нь хөөрөгдөх зэргийн ухаан оросуудад байна, гэхдээ Монголын Засгийн газрын жинхэнэ бодлого, чухал хэргүүдийг орос зөвлөх нар болон Оросын консул чиглүүлэн залж байна гэжээ. Түүнчлэн Хятадын төв Засгийн газар Монголд эзэгнэлээ мөддөө сэргээж чадахгүй. Учир нь Оросын ивээлээс гадна Монголын цэрэг цөөн боловч Хятадын ямар ч түрэлтийг няцааж чадахтайгаа болсон. Хятадууд Оростой тусгай хэлэлцээ хийж, Монголын тухай тохиролцохоос өөр арга байхгүй. Харин Оросуудын хувьд Хятадтай харилцах харилцаагаа Монголтой харилцахаас илүүд үздэг тул Оросууд ч мөн нэгэн адил хэлэлцээ хийхээс буцахгүй байх гэж бичиж байжээ.

Үнэхээр ч удалгүй ЗХУ, Дундад Улсын хоорондын 1924 оны 5 дугаар сарын 31-ний хэлэлцээрийн 5 дугаар зүйлд Гадаад Монгол нь Дундад улсын сувернитетэд орших салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд

Зөвлөлт Засгийн газар түүнийг хүндэтгэнэ гэж тохиролцсон билээ.

АНУ энэ хэлэлцээрийн талаар маш тодорхой мэдээлэлтэй байсан байх бөгөөд олон улсын эрхзүйн хувьд Хятадын сувернитетэд орших салшгүй бүрэлдэхүүн хэсэг атлаа үнэн хэрэг дээрээ Зөвлөлтийн нөлөөний хүрээнд байгаад байдаг урьд өмнө байгаагүй шинэ status quo-г цаашид ажиглахаар нэг хэсэгтээ Хаалган хот дахь Консулын газраа ажиллуулж байжээ.

Консул Самуэл Сокобин, түүний хувь заяа

1893 оны 4 дүгээр сарын 28-нд Нью Джерси мужийн Ессекс дүүргийн Ньюарк боомт хотод америкийн жүүд гэр бүлд төржээ. Тэрбээр Баррингерийн ахлах сургууль, 1911-13 онд Корнеллын их сургуулийн Дорно дахин судлалын салбарт суралцаж төгсчээ. Хятад хэлний сайн мэргэжилтний нэг, АНУ-ын дипломатч, тусгай албаны ажилтан, жүүдийн түүхийн эрдэмтэн байжээ. Хаалган хотод Гадаад Монголын асуудлыг тусгайлан хариуцсан АНУ-ын анхны суурин консулаар томилогдохоосоо өмнө С.Сокобин Гадаад албанд ороод удалгүй 1914-16 онд Шаньхайд мандарин аялгууны орчуулагчийн эрчимжүүлсэн хоёр жилийн сургалт амжилттай дүүргээд, Төрийн департаментийн дэргэд 1916 онд байгуулагдсан тусгай албаны сургалтад хамрагдаж (The Bureau of Secret Intelligence буюу өнөөгийн US Diplomatic Security Service), улмаар дэд консулаар 1916 онд Тяньжинд, 1917 онд Шаньхайд, 1918 онд Нанькинд, 1919-21 онд Чунцин, Шаньтоуд, 1920 оны намар анхны эхнэр Иоаннатайгаа Парист хуримлаж, эргээд Хятадад хамтдаа иржээ. 1921-24 онд Хаалганд Гадаад Монголыг тусгайлан хариуцсан анхны суурин (дэд) консулаар ажиллаж, 1924 онд Хаалганд Ерөнхий консулаар дэвшин томилогджээ. Дараа нь 1924-26 онд Мүгдэнд, 1927-29 онд Фочжоуд, 1929-30 онд Фуцзоуд, 1930-34 онд Мексикийн Умард Салтилло хотод консул, 1934-36 онд Кубын нийслэл Гавана дахь АНУ-ын консул, 1937-1938 онд Төрийн департаментын Алс Дорнодын газарт Нарийн бичгийн дарга, Гадаад албаны 3 дугаар зэргийн ажилтан, 1938-40 онд Циньтаод, 1940-41 онд Японы Кобе хотод Ерөнхий консулаар ажиллаж байгаад 1941 оны 12 дугаар сарын 7-нд Японы агаарын цэргийн хүчин АНУ-ын Хавайн арлын Пёрл Харборг цохилт өгч хоёр орны хооронд дайн эхлэхэд

консулын газраа хааж, Манилад шилжин иржээ. Гэвч удалгүй 1942 оны 1 дүгээр сард АНУ болон бусад орны 15 дипломатчдын хамт япончуудад олзлогдож, (26) 1942-43 оны 11 дүгээр сар хүртэл Кобе хотын ойролцоох уулын аман дахь Японы тусгай зориулалтын хорих ангид тусгаарлагдаж байгаад Гаагын конвенцийн дагуу солилцоогоор суллагджээ. (27) 1944 оноос Төрийн департаментын Алс Дорнодын газарт зөвлөхөөр ажиллаж, гадаад албаны 2 дугаар зэргийн ажилтан болсон байна. Дэлхийн II дайны дараа сүүлчийн томилолтоороо Английн Бирмингхам хотод консулаар ажиллажээ. 1950-иад онд сенатч Жозеф МакКартын нийтийг хамарсан улс төрийн шүүмжлэлд өртөж, Хятадыг коммунистуудад алдсан хэрэгт нэр холбогдож байжээ. Тэр үед Хятадад дипломат болон консулын алба хашиж байсан бусад нөхөд доктор Эрнест Прайс (Ernest B.Price), Жон Сервис (John S.Service), Жулеан Арнольд (Julean H.Arnold), Рое Мельбурн (Roy M.Melbourne) нар сенатын хуралд Самуэл Сокобиныг өндөр үнэлсэн мэдүүлэг өгсөн байдаг. Хожим цагаатсан байна.

С.Сокобин Хятадын еврейн суурин Хэнань муж, дэлхийд тархсан хятад еврейчүүдийн (Kaifeng jews) талаар даацтай судалгаа хийж, нилээд өгүүлэл бичжээ. Тэрбээр 1986 онд 93 насандаа Калифорнийн Санто Клара дүүргийн Пало Алто хотод нас баржээ (хоёр дахь гэргий Франсине Сокобин 1905-2007). (25)

Америкийн эрдэмтэн, дипломатч, хатагтай Алиша Кэмпи 1980 онд С.Сокобинтой гэрт нь хэд хэдэн удаа биеэр уулзаж байжээ. Чухам тэрхүү уулзалт ярилцлага Алиша Кэмпиийг цаашид дурдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чиглэл болж өгсөн ажээ. Тэрбээр Америкийн үндэсний архивын Төрийн департаментийн тасагт хадгалагдаж буй Хаалган дахь Консулын газрын Гадаад Монголтой холбоотой 50 гаруй хавтаст багц баримт материалыг шүүрдэн 1986 онд «АНУ ба Гадаад Монголын хоорондын улс төрийн харилцаа, 1915-1927 он, Хаалган дахь Консулын газрын материалууд» сэдвээр Индианы Их сургуульд улстөрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ. Тэрбээр 1990-91 онд АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд зөвлөхөөр ажиллаж байхдаа дээрх судалгаагаа лавшруулж, 1992 онд «Хаалган дахь (Өвөр Монгол) Америкийн Консулын газрын 1920-1927 оны илтгэлүүдэд тусгагдсан Гадаад Монголчуудын тухай

АНУ-ын Засгийн газрын төсөөлөл» нэртэй томоохон өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгосон юм. Түүний 2009 онд хэвлүүлсэн «XX зууны АНУ-Монголын улс төрийн харилцаан дахь Хятад, Оросын нөлөө» бүтээл нь иж бүрэн судалгаа болсон бөгөөд доктор Ц.Батбаяр оршил бичжээ. Дээрх бүтээлүүд урьд өмнө тун бага мэдэгдэж байсан архивийн материалуудыг эрдэм шинжилгээний эргэлтэд анхлан оруулж, Монголын нэн шинэ үеийн гадаад харилцааны түүхийг тодруулахад жинтэй хувь нэмэр оруулсан юм. Алиша Кэмпи дурдсан номоо Д.Уламбаяр би бээрт Вашингтон хотноо дурсгал болгон өгсөн билээ.

Төгсгөл

Самуэл Сокобин бол Хаалган хотод Гадаад Монголыг тусгайлан хариуцсан АНУ-ын анхны суурин консул бөгөөд тиймээс ч нийслэл Хүрээнд ирж тухайн үеийн төр засгийн өндөр албаны бүх зүтгэлтнүүдтэй биечлэн уулзаж, Гадаад Монголын улс төр - эдийн засгийн нөхцөл байдал, Зөвлөлт Оросын хоёр нүүрт бодлогын үнэн дүр төрх, мөн чанарын талаар Вашингтонд үнэн зөв мэдээлэл бэлтгэн илгээж байжээ. Тэрбээр Ардын эрхт Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Гадаад хэргийн тэргүүн сайд Д.Бодоотой уулзан АНУ-тай дипломат харилцаа тогтоож, худалдааны харилцааг улмаар бадруулан хөгжүүлэх тухайд ноот бичиг, мөн Хэмжээт эрхт Богд хаантай биеэр уулзан Монгол-Хятадын харилцаанд АНУ-ыг зуучлуулах хүслээ илэрхийлсэн түүний албан захидлыг албан ёсоор тус тус гардан авсан юм. Самуэл Сокобин дурдсан баримт бичгүүдийг англи орчуулга, тайлбарын хамт Төрийн департаментэд яаралтай илгээсэн байна. Америк консул анхныхаа аялалаар л монголчууд бол хятад үндэстэн биш, тэднээс огт өөр бие даасан тусгаар үндэстэн бөгөөд энд Хятадын ямар ч нөлөө байхгүйг мэдэрчээ. Мөн тэрбээр АНУ-ын худалдааны эрх ашгийн үүднээс АНУ-Гадаад Монголын худалдааны харилцааг хөгжүүлэхийн төлөө хичээнгүйлэн зүтгэж байв. АНУ-ын Засгийн газар “нээлтэй хаалга”-ны бодлогыг зарласны дараа дипломат ажиллагааг “худалдаажуулах” эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан юм. Сайхь бодлого хоёр талтай байсан бөгөөд нэгд, Хятадад байрласан Wall street-ийн хөрөнгийг дипломат арга хэрэгслээр хамгаалах, хоёрт,

Хятад дахь хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч, Wall street-ийн хөрөнгөөр АНУ-ын гадаад бодлого, дипломат ажиллагааг идэвхтэй дэмжихэд оршиж байв. АНУ-ын Засгийн газар 1913 онд Чин гүрний сууринд шинээр тогтносон Дундад улсыг албан ёсоор хүлээн зөвшөөрсний зэрэгцээ тэнд Америкийн худалдаа-эдийн засгийн ашиг сонирхлыг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлж эхэлжээ. С.Сокобин бол Ардын эрхт Монгол Улс-АНУ-ын хооронд албан ёсны харилцааг эхлүүлэх үндэс суурийг тавилцсан АНУ-ын анхны дипломатч байсан юм. Гадаад Монголын талаарх АНУ-ын Засгийн газрын бодлого нь Хятадад явуулах “нээлттэй хаалга”ны бодлогын үндэс болсон тус улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хэвээр үргэлжлүүлэх зарчимд захирагдаж байсанд орших бөгөөд энэ бодлого 1945 оны гурван гүрний тэргүүн нарын Ялтын нууц хэлэлцээр хүртэл үргэлжилсэн юм.

1920-иод оны Монгол - Америкийн харилцааг олон улсын эрхзүйн үүднээс *ad hoc* харилцаа байсан гэж дүгнэж болно. Улс буюу Засгийн газрын хооронд бие биеэ албан ёсоор харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх бусад учир шалтгаантай боловч тодорхой нэгэн асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцаа, дипломат ажиллагаанд шинээр гарч ирсэн бөгөөд эдүгээ ч практикт биеллээ олсоор байгаа юм. Үүнийг дипломатын болон олон улсын эрхзүйд *ad hoc* хүлээн зөвшөөрөх үйл гэх агаад *ad hoc* хүлээн зөвшөөрснөөр тухайн тохиолдлын хүрээнээс хэтэрсэн эрхзүйн үр дагавар үл гардаг.

1924 оны 5 дугаар сарын сүүлчээр Хаалган хотноо шинээр томилогдсон консул ноён Э.Ф.Стентон¹³ ажилдаа оржээ. Шинэ консул

13 Stanton, Edwin Forward (1901-68) АНУ-ын дипломатч, С.Сокобины ажлыг хүлээж авсан. 1901 оны 2 дугаар сарын 22-нд Нью Йоркт төрсөн. Өмнөд Калифорний их сургууль төгссөн, тусгай албаны сургалт дүүргэсэн, хятад судлаач, 1921 онд Гадаад албанд орсон. Бээжинд нэг жил хэлний мэргэжил дээшлүүлсэн. 1923-24 онд Мүгдэнд дэд консул, 1924-26 онд Хаалганд дэд консул, 1927-29 онд Шаньдун мужийн төв Цзинаньд консул, дараа нь Бээжинд АНУ-ын ЭСЯ-нд II нарийн бичгийн дарга, 1932-37 онд Цзинань, Кантон, Уханьд консул, 1938-41 онд Шаньхайд консулаар ажиллаж байгаад баривчлагдсан, 1941-42 онд Японд тусгай зориулалтын ангид тусгаарлагдаж, Гаагын конвенцийн дагуу солилцоогоор суллагдсан. 1943-44 онд Төрийн департаментын Алс Дорнодын газрын даргын туслах, 1944-45 онд мөн газрын орлогч дарга, 1945-1946 онд Канадын Ванкуверт Ерөнхий консул, 1946-47 онд АНУ-аас Тайландын Вант улсад суух анхны Онц элчин (Envoy Extraordinary), Бүрэн эрхт сайд (Minister Plenipotentiary) 1947-53 онд элчин сайдаар (ambassador) ажиллаж байгаад тэтгэвэрт гарчээ. МакКартизмын шуугианд өртөөгүй. Гадаад харилцааны зөвлөлийн гишүүн. Тэрбээр элчингээр ажиллаж байхдаа Тайландад цэрэг-техникийн томоохон тусламж үзүүлэх хөтөлбөр санаачилж, гардан удирдсан ажээ. 1956 онд “Brief Authority: Excursions of a Common Man in an Uncommon World” дурдагталаа хэвлүүлсэн байна. 1968 оны 8 дугаар сард Коннектикутын Бриггенорт хотноо нас баржээ.

ажилдаа ороод удалгүй Вашингтонд мэдээлэхдээ Богд хаан саяхан таалал төгсөж, улстөрийн байдал ээдрээтэй болсон ч Хүрээн дэх Америкийн худалдааны үйл ажиллагаа хэвийн явагдаж байна гэжээ. Хаалган хотноо Гадаад Монголыг тусгайлан хариуцсан сүүлчийн суурин консул бол Л.Кларк¹⁴ юм.

1920-иод оны II хагасаас Хятадад дотоодын иргэний дайн, самуун үргэлжилж Хаалган хотод тулж ирсний улмаас Вашингтоны удирдлага Хаалган дахь Консулын газраа 1927 оны 4 дүгээр сарын 18-нд түр хааж, Бээжин дэх Ерөнхий Консулын газарт шилжүүлсэн нь түр биш, бүр мөсөн хаасан хэрэг байв. Ийнхүү АНУ-ын Хаалган дахь Консулын газрын зургаан жилийн түүх дуусгавар болсон ажээ.

Ном зүй

1. Р. Болд. Монголын тусгаар тогтнол ба АНУ (1910-1973). УБ., 2008. 136 дахь тал
2. Roy Chapman Andrews. Across Mongolian Plains-A Naturalist's Account of China's "Great Northwest". N.Y.:1921, pp. 5-24
3. Үндэсний түүхийн музейн архив. Ж.Цэвээний холбогдолтой материалууд. №24
4. The Diluv Khutagt, Memoirs and Autobiography of Mongol Buddhist Reincarnation in Religion and Revolution by Owen Lattimore and Fujiko Isono. 1982, Wiesbaden., p.91
5. Мөн тэнд p. 167
6. Мөн тэнд p. 169
7. Alicia Campi...The Impact of China and Russia on United States-Mongolian Political Relations in The Twentieth Century. The Edwin Mellen Press. N.Y. 2009, pp. 65-78
8. Мөн тэнд
9. Ц.Пунцагноров. «Монгол-Америкийн харилцааны туулсан зам, хамтын ажиллагааны өнөөгийн төлөв»-“Өрнө-Дорно” сэтгүүл. ШУА. 1994-1995, №1-2, 40 дэх тал
10. А.Сампи, p.54

¹⁴ Clark, Lewis 1926-27 онд Хаалган хотноо Гадаад Монголыг тусгайлан хариуцсан АНУ-ын сүүлчийн суурин дэд консул, 1928-32 онд Уханьд консул, 1940-43 онд Оттавад консул 1949 онд Чуньцзин, Гуаньчжоуд консул, 1955 онд Алжирт консулаар ажиллаж байжээ.

11. Жонатан Эдлтон. Нэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, 1987-2012. УБ., 2012
12. A.Campi, p.80
13. Alicia Campi...The Impact of China and Russia on United States-Mongolian Political Relations in the Twentieth Century. The Edwin Mellen Press. N.Y. 2009, pp. 97-105
14. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. 1 боть. УБ., 1964, 6 дахь тал
15. A.Campi. pp.109-113
16. Б.Лхамсүрэн. Из истории внешних сношений Монгольской Народной Республики (1921-1945гг) “Современная Монголия”, 1957. №5-6, с.37
17. Документы внешней политика СССР. Т.4, с. 370-371
18. НТА. Ф.1. Т.3.ХН.33
19. Alicia Campi...
20. Alicia Campi...
21. «Уриа» сонин. №11-15
22. A.Campi. pp. 137-152
23. A.Campi. pp. 158-173
24. A.Campi. pp. 189
25. Hoover Institution Archives, Stanford University. California, US, Overview of the Samuel Sokobin papers, American consular official in China, 1914-1940; collector of rare books on China.
26. New York Evening Post. January 3 1942
27. Huntington Daily News. December 1 1943